



**ХӨВСГӨЛ
АЛТАНДУУЛГА**

**2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



КОМПАНИЙН ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

“Хөвсгөл Алтандуулга” ХК

Үүсгэн байгуулагдсан огноо 1996.04.25

Хувь нийлүүлсэн хөрөнгө 157,342 мянган төгрөг

Компанийн байршил Хөвсгөл, Тариалан, Мандал

Хувьцаа эзэмшигчдийн тоо 327 (201912.31-ний байдлаар)

Ажиллагсдын тоо 77



Эргэлтийн талбай - 7050 га

Үр тарианы агуулах – 6500 тн

Үр тариа тариалалт:



Гурилын үйлдвэр - хоногт 100 тн

Тэжээлийн үйлдвэр - хоногт 10 тн

Гурил, тэжээлийн үйлдвэр



ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 –р сарын 23

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав
- Компанийн дүрмийн сан нэмэгдсэн тул холбогдох өөрчлөлтийг дүрэмд өөрчлөлт оруулав
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоов
- Ногдол ашиг хуваарилах тухай тогтоол танилцуулав

ТУЗ, хороодын үйл ажиллагаа

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулан, хурлын материалыг хуульд заасан хугацаанд СЗХ, Хөрөнгийн биржид хүргүүлэв.
- 2019 онд нийт 4 удаа хуралдаж, 5 удаа эчнээ санал хураалт явуулж төлөвлөсөн болон цаг үеийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлэв.
- Нэгж хувьцаанд 120 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргаж, УБ хот дахь хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг авах хүсэлтийг гүйцэтгэх албанд хүргүүлэх ажлыг гүйцэтгэв.
- Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хувьцаа эзэмшигчдийн компанийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах зорилгоор төв, орон нутгийн телевиз, сонин, мэдээллийн бусад хэрэгсэл, компанийн цахим хуудсаар компанийн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж ажиллаа.
- Нээлттэй нийгмийн форумас Хувьцаат компаниудын ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нарын дунд зохион байгуулсан сургалтад ТУЗ-ийн зарим гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга оролцов.
- ТУЗ-ийн зарим гишүүд компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, зөвлөгөө өгч, сургалт хийн, хаврын тариалалт, намрын ургац хураалтын үеэр орон нутагтаа очиж ажиллав.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагдсан China Import үзэсгэлэнд 2019 оны 11 сард оролцож, үзэсгэлэнд оролцогчдод мэдээлэл өгч, хамтран ажиллах сонирхолтой компаниудтай ганцаарчилж уулзан, 1 компанитай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

БНХАУ-д бүтээгдэхүүн экспортлох гурилын үйлдвэрүүдийг магадлан итгэмжлэх хяналтанд хамрагдлаа.

Компанийн ажилтнуудыг Байгаль нуурын эрэгт амраав



Монгол улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойг ургац арвинтай угтлаа





ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Тариалалт ба ургац

Таримлын төрөл	Тариалалт /га/	Ургац /тонн/
Улаанбуудай	4353	6122.2
Арвай	20	12.7
Овьёос	24	60.7
Рапс	250	104.0
Бусад	9	1.9
Нийт	4656	6273.5

- Улаанбуудайн 1 га-ийн ургац 14 центнэр буюу улсын дунджаас өндөр байв
- Үрийн тариалалтанд 212 га уринштай талбайг сонгон тарьж, 450 тонн үрийн буудай нөөцлөв
- ОХУ-ын органик гаралтай цуврал бордоог ашиглав
- Уриншийг 2494 га-д хийв
- Ургац хураалтад зориулж CASE IH Axial FLOW 9240 комбайн худалдан авав
- Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг өөрийн хөрөнгөөр 258 га-д хийж, улсын төсвийн хөрөнгөөр 948 га-д хийлгэх ажлыг эхлүүллээ.

ГУРИЛ, ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

- 2019 онд 7.8 мян тн буудай тээрэмдэж гурил 6.3 мян.тн, тэжээлийн хивэг 1.3 мян тн тус тус үйлдвэрлэлээ.
- Үйлдвэрт зарим нэмэлт тоног төхөөрөмжийг суурилуулж, их засварын ажлыг хийлээ.
- Гурилын үйлдвэрийн өргөтгөлийг стандартын дагуу барьж ашиглалтанд оруулав.
- Бүхэл үрийн гурилыг шинжилгээнд хамруулан, хэрэглэгчдэд нийлүүлж эхлэв.
- Бүтээгдэхүүн баяжуулах туршилт шинжилгээ хийж, дозатор суурилуулав

Гурилын үйлдвэрлэл





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГО, ҮР ДҮН

	2016	2017	2018	2019
САНХҮҮГИЙН ОРЛОГО, сая төг				
Үр тариа, тэжээлийн борлуулалт	620	404	1,526	1,423
Гурилын борлуулалт	2,289	2,000	6,083	6,402
Бусад	349	57		137
НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО	3,258	2,461	7,609	7,961
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,347	1,997	6,551	5,898
НИЙТ АШИГ	911	464	1,059	2,064
Боловсон хүчний холбогдолтой зардал	96	167	195	275
Ерөнхий удирдлагын бусад зардал	148	197	508	494
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	244	364	703	769
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ	666	100	356	1,295
Санхүүгийн зардал	480	410	252	179
Ердийн бус орлого зардал	(270)	346	235	79
ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО	(84)	37	339	1,194
Татварын зардал	1	0	24	69
ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	(85)	37	315	1,125



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ӨР ТӨЛБӨРИЙН БАЙДАЛ

	2016	2017	2018	2019
Бэлэн Мөнгө	50	506	1261	142
Авлага	441	1443	1477	1655
Бараа Материал	1426	1119	3964	2533
Бусад эргэлтийн хөрөнгө	174	152	611	1049
Нийт эргэлтийн хөрөнгө	2091	3221	7313	5379
Газар эзэмших эрх ба биет бус хөрөнгө	463	3379	3379	3379
Барилга	1181	5236	6512	6681
Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	5209	13054	13922	14966
Тавилга, эд хогшил	46	41	77	127
Нийт үндсэн хөрөнгө ба газар	6899	21710	23890	25154
Элэгдэл	2514	10426	12315	13798
Цэвэр үндсэн хөрөнгө	4385	11284	11575	11356
Барааны тэмдэг ба хөрөнгө оруулалт	4	188	125	62
НИЙТ ХӨРӨНГӨ	6480	14693	19013	16797
Нийт богино хугацаат өглөг	2708	4043	6038	5740
Нийт урт хугацаат өглөг	743	202	202	446
Нийт өр төлбөр	3451	4244	6240	6186
Хувьцаа	102	102	157	157
Халаасны хувьцаа				-532
Нэмж төлөгдсөн капитал	0	0	3356	3356
Хөрөнгийн дахин үнэлгээ	0	7383	5993	5126
Хуримтлагдсан Ашиг	2926	2963	3267	2504
Нийт өөрийн хөрөнгө	3029	10449	12773	10611
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГ	6480	14693	19013	16797



ЭРСДЛИЙН БА ЧАНАРЫН УДИРДЛАГА

Эрсдлийн ба чанарын удирдлага

- БНХАУ-д бүтээгдэхүүн экспортлох гурилын үйлдвэрүүдийг магадлан итгэмжлэх хяналтанд хамрагдлаа. Энэхүү магадлан итгэмжлэх ажлын хүрээнд боловсруулах үйлдвэрлэл болон газар тариалангийн үйлдвэрлэл чанарын хяналтын тогтолцоогоо сайжруулж, ажиллагсдыг сургалтанд хамруулах ажлууд цогцоор хийгдсэн.
- Бүтээгдхүүний аюулгүйн тэмдгийн гэрчилгээ авах бэлтгэл ажлыг хангаж, Монгол улсын хүнсний аюулгүйн гэрчилгээг хүлээн авсан 7 дахь аж ахуйн нэгж болж чанарын баталгаажуулалтыг авлаа.
- 2018 онд нэвтрүүлсэн “Чанарын удирдлагын тогтолцоо”-ны явцын магадлах аудитад амжилттай хамрагдлаа.
- Дотоод аудитын ажлыг эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгож хэвшүүлэх, удирдлагын мэдээллийн системийг оновчтой болгоход чиглүүлж, ажлын төлөвлөгөөг гарган ажиллалаа.
- 2019 онд ургацын даатгалд 212 га талбайг хамруулж, нийт талбайд ган болон хяруу тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлдэг цуврал бордоог ашиглав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- Ажиллагсдын ажлын байрны тав тухтай байдлыг хангах, стандартын шаардлагад бүрэн нийцүүлэх зорилгоор үйлдвэрийн дэргэд өртгөтгөл барьж, ажиллагсдын хоолны газар, ариун цэврийн өрөө зэргийг шинээр тохижуулав.
- ХАБЭА, хувь хүний хөгжил, стандартууд хэвшүүлэх чиглэлээр нийт 30 сургалт зохион байгуулагдсан байна.
- Ажиллагсдыг эрүүл мэндийн хуваарьт үзлэг хамруулахаас гадна Улаанбаатар хотоос нарийн мэргэжлийн эмч нарыг авчран үзлэгт хамрууллаа
- ХАБЭА-н дүрэм журам, стандартуудыг шинэчлэн баталж аюулгүй ажиллагааны заавар, сануулга, таних тэмдгийг шинэчлэн байрлуулав.

